

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
БАГИЙН 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2026 оны 06 сарын 05

Нэг. Бүтэц зохион байгуулалтын талаар

2026 онд чанарын алба нь доорх орон тоогоор ажиллаж байна. Төвийн хэмжээнд орон тооны ажилчид үгүй хавсран гүйцэтгэдэг болно.

Албан тушаал	Нэр	Ажилласан хугацаа	Ажилласан жил мэргэжлийн зэрэг
Чанарын багийн дарга	Л.Эрдэнэбулаг	2022 оноос ЭМТҮЧАБ-н багийн ахлагч	Хүүхдийн эмчээр 7 жил ажилласан.
Чанарын менежер	Б.Үүрийнцолмон	2025 оноос ажиллаж байна.	Уламжлалтын их эмч, Хавсран гүйцэтгэдэг
Аюулгүй байдал, эрсдэлийн менежер болон чанарын мэдээлэл хариуцсан ажилтан	Д.Түмэн-Өлзий	2023 оноос ажиллаж байна.	Уламжлалтын их эмч, Хавсран гүйцэтгэдэг

Дүгнэлт:

ЭМТҮЧАБ-ын баг нь 2026 онд орон тооны бус гишүүдтэй үйл ажиллагаа явагдаж байна. 2023 онд чанарын багийн ахлагч, чанарын менежер, чанарын мэдээллийн ажилтантай байсан бол 2025 оноос чанар менежер болон аюулгүй байдал эрсдэл хариуцсан ажилтныг тус тусад нь их эмч томилон 2019 оны 166/565 тушаалыг үндэслэн томилон тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2025 оны 12 сарын 25-ны өдрийн төвийн даргын А/37 тоот тушаалын дагуу чанарын багийн дарга, чанарын менежер болон аюулгүй байдал, эрсдэлийн менежер гэсэн орон тооны 1, орон тооны бус 2 гишүүдтэй ажиллаж байна.

Хоёр. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тогтмол хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр

№	Хяналт шинжилгээ үнэлгээний чиглэл	Хийгдсэн үйл ажиллагаа талаар	Хяналт үнэлгээний үр дүн
1.	Ижил мэргэжилтний үнэлгээ	Улирал тутамд бие биедээ үнэлгээ хийж үнэлгээний дүнг тасаг нэгжээрээ хэлэлцэн чанарын багийн хурал зохион байгуулан ажилласан.	Улирал тутамд хяналт тавин сайжруулан ажиллаж байна. - Өвчний түүх бичилт - Сувилахуйн оношны ерөнхий загвар - Сувилгааны түүх бичилт сайжирсан.
2.	Эмчилгээ сувилгааны гардан үйлдлийн үнэлгээ	Үнэлгээг улиралд 1 удаа гардан үйлдлийн шалгалт өгч ажилласан.	Сар тутамд үнэлгээг хийж үнэлгээний дүнг ур чадварын урамшуулалтай холбон ажилласан.
3.	Цэвэрлэгээ үйлчилгээний стандартын хяналт	Үнэлгээг 7 хоног тутамд 2 удаа гардан үйлдлийн шалгалт өгч ажилласан.	Сар тутамд үнэлгээг хийж үнэлгээний дүнг ур чадварын урамшуулалтай холбон

	үнэлгээ		ажилласан.
--	---------	--	------------

Гурав. Чанар сайжруулах чиглэлээр ажилтнуудад сургалт, харилцан туршлага солилцох ажлыг тогтмол зохион байгуулж, тасралтгүй суралцах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр

3.1. Чанар сайжруулах аян - 3 удаа хийж, 195 хүн хамрагдсан.

№	Аяны сэдэв	Аяны хугацаа	Оролцсон хүний тоо	Хийгдсэн ажиллагаа	Үр дүн
1.	Осол гэмтлээс сэргийлэх нөлөөллийн аян	2026.01.15 - 2026.02.15	61	Аяны хүрээнд байгууллагын дотоод болон гадна орчны эрсдэлийг үнэлж, халтиргаа гулгааг арилгах, анхааруулга санамж байршуулах, орнуудыг хашлагатай болгох зэрэг аюулгүй байдлыг хангах 4 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. Мөн байгууллагын 30 ажилтан болон хэвтэн эмчлүүлэгч 31 иргэнд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт орж, цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан сэрэмжлүүлэг постер, видео бичлэгүүдийг олон нийтэд түгээн ажилласан.	Ажлын байр, хүүхдийн орчны аюулгүй байдал сайжирч, осол гэмтэл гарах магадлалыг ойролцоогоор 30 хувиар бууруулсан.
2.	“Миний мэдэх сувилагч” эссэ бичлэгийн уралдаан	2026.04.14 - 2026.04.20	119	Сувилахуйн тусламж, үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд таниулах, сувилагч мэргэжлийн нэр хүндийг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад энэхүү мэргэжлийн талаар зөв ойлголт, эерэг хандлага төлөвшүүлэх зорилгоор “Миний мэдэх сувилагч” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг амжилттай зохион байгуулсан.	Сурагчдын бүтээлч сэтгэлгээ болон идэвх оролцоог нэмэгдүүлснээс гадна ахлах ангийнхны ирээдүйн мэргэжил сонголтод эергээр нөлөөлөхүйц ач холбогдолтой
3.	Эрдэм	2026.05.07	15	Эмчилгээний тасгаас	Төвийн

	шинжилгээний хурал	- 2026.06.12		сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн судалгааны ажлыг дэмжих зорилгоор нийгмийн эрүүл мэнд, сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулжээ. Үйл ажиллагааны хүрээнд ажилчид багт хуваагдан сэдэв сонгож, анхан шатны шалгаруулалтыг зохион байгуулсан.	сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээ, судалгаа шинжилгээ хийх ажил бодитоор дэмжигдэж, тэдний ур чадвар хөгжих суурь тавигдана.
--	-----------------------	-----------------	--	---	--

3.2. Разбор (хэлэлцүүлэг) – 2026 оны хагас жилийн байдлаар 1 хэлэлцүүлэг, таагүй 2 тохиолдлыг 2 багаар хэлэлцүүлэг хийж 18 хүн оролцож 2 зөвлөмж гарган түүний мөрөөр уламжлалт эмчилгээ болон яаралтай түргэн тусламжийн талаар сургалт зохион байгуулан гардан үйлдлийн шалгалт авч үр дүнг тооцон хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд давтан шалгалт авах үйл ажиллагаа хэрэгжүүлсэн.

3.3. Илтгэл, судалгаа: 4 удаа

- ✓ **Өсвөр үеийн хүүхдүүдийн хахалтын үед үзүүлэх анхны тусламжийн мэдлэгийг үнэлэх нь**

Өсвөр үеийн хүүхдүүдийн анхны тусламж, ялангуяа хахалтын үед авах арга хэмжээний талаарх мэдлэг, ойлголтын түвшинг тодорхойлох, цаашид энэ чиглэлийн сургалт, мэдээллийг сайжруулах хэрэгцээг илрүүлэх зорилгоор Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 12 дугаар сургууль болон 153 дугаар сургуулийг түшиглэн явуулсан. Судалгааг ЕБС-ийн 5-12 дугаар ангийн (10-18 насны) нийт 207 сурагчдаас асуумж судалгааны аргаар авсан бөгөөд дараах үр дүн гарсан.

- **Ерөнхий мэдлэгийн түвшин:** Сурагчдын дийлэнх нь хахалтын шинж тэмдгийг таньдаг боловч амь аврах үндсэн арга болох Геймлихийн маневрыг гүйцэтгэх дарааллыг зөв мэддэг сурагчид ердөө **20-30%-ийг** эзэлж байна.
- **Түгээмэл алдаатай хандлага:** Сурагчдын олонх нь хахсан хүнд "ус уулгах" эсвэл "нуруу руу нь цохих" зэрэг уушгины бөглөрлийг улам гүнзгийрүүлэх эрсдэлтэй буруу тусламж үзүүлэхийг зөв арга гэж эндүүрч байна.
- **Сэтгэл зүйн бэлтгэл ба хандлага:** Сурагчдын **60-аас дээш хувь** нь хүнд анхны тусламж үзүүлэх чин хүсэлтэй боловч "буруу аргаар туслаад улам хохирол учруулж магадгүй" гэсэн айдастай, өөртөө итгэлгүй байна.
- **Сургалтын хэрэгцээ шаардлага:** Оролцогчдын **90 орчим хувь** нь сургуулийн орчинд анхны тусламжийн (ялангуяа Геймлихийн маневр) практик сургалтыг зохион байгуулах нэн шаардлагатай гэж үзсэн. Сурагчид зөвхөн эмнэлгийн ажилтан хүлээх биш, өөрсдөө амь аврах боломжтойг ухамсарлаж эхэлсэн байна.

- ✓ Сэргээн засах төвөөр үйлчлүүлж буй 3-14 насны хүүхдийн нойрны чанарыг үнэлэх, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх зорилгоор хэвтэн эмчлүүлэх тасгаар үйлчлүүлсэн 91 хүүхдийг асуумж болон ажиглалт судалгаанд хамруулсан. Сэргээн засах эмчилгээний нөлөөгөөр хүүхдүүдийн гүн нойрны үргэлжлэх хугацаа болон чанарт мэдэгдэхүйц ахиц гарсан. Хүүхдүүдийн хоногт унтах нийт цаг нь нэмэгдсэн нь бие махбод эмчилгээний явцад зарцуулсан энергийг нөхөх болон булчингийн амралтыг гүнзгийрүүлэх хэрэгцээтэй шууд холбоотой юм. Унтах хугацаа уртсаж, гүн нойр нэмэгдсэнээр хүүхдийн өдрийн идэвх сайжирч, сэргээн засах дасгалуудыг гүйцэтгэх чадвар болон сэтгэл зүйн бэлэн байдал нэмэгдэж байгаа нь "ээрэг нойр- үр дүнтэй нөхөн сэргээлт" гэсэн хамаарлыг баталж байна.
- ✓ Хүүхдийн ханиад томууны дараах сэргээн засах эмчилгээний үр дүнг судлах нь

Энэхүү судалгааг хүүхдийн дунд тохиолдох ханиад, томууны дараах сэргээн засах эмчилгээ нь хүүхдийн биеийн байдал, дархлаа, амьсгалын үйл ажиллагаанд хэрхэн чөлөөлж байгааг үнэлэх зорилгоор төвөөр үйлчлүүлсэн 0-10 насны 70 хүүхдийг хамруулан хийсэн. Судалгааны явцад уламжлалт сэргээн засахын цогц эмчилгээ нь хүүхдийн амьсгалын замын үрэвслийг богино хугацаанд намдааж, уушгины үйл ажиллагааг бүрэн сэргээхэд чухал нөлөө үзүүлж, зөвхөн шинж тэмдгийг дарахаас гадна амьсгалын эрхтний үйл ажиллагааг бүхэлд нь дэмжиж, уушгины агааржуулалт, цэр гадагшлах явц, хүчилтөрөгчийн солилцоог сайжруулахад ач холбогдолтой байсан. Эмчилгээний үр дүнд хүүхдийн ерөнхий биеийн эсэргүүцэл сайжирч, дархлааны тогтоц бэхжиж, өвчин архагших эрсдэл буурсан. Хүүхдийн ханиадны дараах нөхөн сэргээлт бол зөвхөн эмчилгээ биш, ирээдүйн архаг өвчлөлөөс сэргийлэх хамгийн том хөрөнгө оруулалт юм.

- ✓ Сувилагчийн эцэг эх, асран хамгаалагчдад өгч буй зөвлөгөө, мэдээллийн үр дүнг судлах нь

Сувилагчийн өгч буй зөвлөгөө, мэдээллийн чанар, хүртээмж болон эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл ханамжийг үнэлэх зорилгоор Хүүхдийн сэргээн засах төв болон ЭХЭМҮТ-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч буй хүүхдүүдийн 87 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулан сувилагчийн өгч буй зөвлөгөө, мэдээллийн чанар, хүртээмж болон харилцаа хандлагын талаар үнэлгээ авсан.

Судалгааны үр дүнгээс харахад ихэнх оролцогчид сувилагчаас тогтмол болон зарим тохиолдолд зөвлөгөө, мэдээлэл авч байгаа нь сувилагчийн нийгмийн эрүүл мэндэд гүйцэтгэх үүрэг чухал болохыг харуулж байна. Мөн оролцогчдын дийлэнх нь сувилагчийн өгсөн мэдээллийг ойлгомжтой, хэрэгцээтэй гэж үнэлсэн нь сувилагчийн зөвлөгөө нь эцэг эхийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөтэй байгааг илтгэж байна.

3.4. Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт – 3 удаа нийт 58 хүн хамрагдсан.

№	Сэдэв	Хамтран ажилласан байгууллага	Оролцсон тоо	Хэзээ	Гарсан үр дүн
1.	Хүүхдийг болзошгүй эрсдэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нь	СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсийн Хүүхдийн асуудал хариуцсан ажилтан Дэслэгч Б.Тэлмэн	30 ажилтан 31 үйлчлүүлэгч	2026.01.27	Ажилчид болон үйлчлүүлэгчдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилж ажлын байр болон хүүхдийн орчны аюулгүй байдал сайжирч, осол гэмтэл гарах магадлал буурсан.
2.	Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх нь	Эх барих эмэгтэйчүүдийн их эмч О.Одмандах болон Mongolpharm Trading LLC (Монгол фарм) байгууллагын эмч төлөөлөгч	20	2026.03.06	Төвийн эмэгтэй ажилчдын умайн хүзүүний хорт хавдрын талаарх мэдлэг нэмэгдэж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдах зөв зан үйл, дадал

					төлөвшихөд чухал ач холбогдолтой.
3.	Эрүүл мэндийн болон сурталчилгааны улсын албаны “Гамшгаас хамгаалах команд штаб”-ын сургалт	Онцгой байдлын ерөнхий газар болон Нийслэлийн эрүүл мэндийн газар	7	2026.05.11-2026.05.15	Эрүүл мэндийн салбарын гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, удирдах бүрэлдэхүүний шийдвэр гаргах чадавхыг нэмэгдүүлэх, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах ач холбогдолтой.

3.5 Үзүүлэх сургууль

Сайн туршлага 2026 арга хэмжээнд оролцохоор бэлтгэн ажиллаж байна.

3.6 Тэмцээн - 1 удаа нийт 20 хүн оролцсон.

Төвийн эмчилгээний тасгаас сувилагч, туслах сувилагч нарын дунд “Сувилахуйн практик ур чадвар, харилцааны чадварыг үнэлэх” тэмцээнийг 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Тэмцээнд нийт 5 баг оролцож, сувилагч болон туслах сувилагч нар дараах чиглэлээр мэдлэг, ур чадвараа сорин оролцсон. Үүнд:

- Ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой багийн асуулт
- Сувилагч нарын гардан үйлдэл
- Туслах сувилагч нарын гардан үйлдэл
- Яаралтай тусламжийн кейс дээр ажиллах
- Уламжлалт сэргээн засах тусламж үйлчилгээг хамтран үзүүлэх

Тэмцээний үеэр оролцогчид багийн зохион байгуулалт, харилцаа хандлага, яаралтай нөхцөлд шийдвэр гаргах чадвар, гардан үйлдлийн ур чадвараар өрсөлдөн оролцсон бөгөөд бодит нөхцөлд ажиллах чадамжийг үнэлсэн үр дүнтэй арга хэмжээ болсон.

3.7 Өдөрлөг - 2 удаа зохион байгуулсан нийт 69 хүн оролцсон.

✓ Сувилагч мэргэжил танилцуулах өдөрлөг

Сувилахуйн тусламж, үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд таниулах, сувилагч мэргэжлийн нэр хүндийг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мэргэжлийн талаар зөв ойлголт, эерэг хандлага төлөвшүүлэх, цаашдын мэргэжил сонголтод нь дэмжлэг үзүүлэх зорилгоор сувилагч мэргэжлийг сурталчлах өдөрлөгийг амжилттай зохион байгуулсан. Өдөрлөгт Нийслэлийн ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчид оролцож, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа болон сувилагч мэргэжлийн онцлог, ажлын орчинтой биечлэн танилцсан нь онцлог байв.

Өдөрлөгийн хүрээнд:

Сурагчдад онол, практик хосолсон цогц мэдээлэл, танилцуулгыг хүргэсэн.

Сувилагч М.Нямцэрэн “Амин үзүүлэлт гэж юу вэ?” сэдвээр илтгэл танилцуулж, хүний амин чухал үзүүлэлтүүдийн ач холбогдол, тэдгээрийг хэмжих аргачлал, сувилахуйн тусламж үйлчилгээний өдөр тутмын хэрэглээг энгийн ойлгомжтой байдлаар тайлбарлав. Үүний зэрэгцээ сувилагч нар өөрсдийн ажлын онцлог, үүрэг хариуцлага, мэргэжлийн үнэ цэнэ, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.

Сурагчдад сувилахуйн анхан шатны ур чадварыг танилцуулах зорилгоор үзүүлэх сургалтыг зохион байгуулж, дараах чадваруудыг практик байдлаар үзүүлэн таниулсан. Үүнд:

- Артерийн даралт хэмжих

- Биеийн халуун хэмжих
- Амьсгал, судасны цохилт тоолох
- Тарилга хийх арга техник
- Боолт хийх аргачлал

Сурагчид өөрсдөө идэвхтэй оролцож дадлага хийснээр сувилагч мэргэжлийн бодит ажлын орчныг мэдрэх, сонирхох боломж бүрдсэн.

Хоол зүйч Б.Ялалтцэцэг 14–18 насны өсвөр үеийн хооллолтын онцлог, насанд тохирсон зөв хооллолтын зөвлөмжийг өгч, тогооч нартай хамтран өөрсдийн ажил мэргэжлийг танилцууллаа. Энэ үеэр зутан шөл, хоёр төрлийн үндсэн хоол, хачир салат зэрэг хоолыг бэлтгэн танилцуулж, эрүүл зөв хооллолтын талаар практик мэдээлэл хүргэсэн.

Мөн хөдөлгөөн засалч Т.Дэлгэрмаа амьсгалын болон сунгалтын дасгал зааж, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхийн ач холбогдлыг тайлбарлан сурагчдад зөвлөгөө өгч ажилласан.

✓ **"Халдвараас сэргийлье – Эрүүл дадлыг хэвшүүлье" сэдэвт өдөрлөг**

"Эрүүл үрс" төвийн Халдвараас сэргийлэх хяналтын багаас 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр тус төвийн байранд "Халдвараас сэргийлье – Эрүүл дадлыг хэвшүүлье" сэдэвт цогц өдөрлөгийг амжилттай зохион байгуулсан. Уг арга хэмжээнд байгууллагын ажилтан албан хаагчид болон хэвтэн эмчлүүлж буй хүүхдүүд, тэдний эцэг эх, асран хамгаалагчид өргөнөөр хамрагдсан.

Өдөрлөгийн хүрээнд хариуцсан их эмч нар амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр лекц уншиж, сувилахуйн багийнхан гар угаалтын зөв техник болон амны хаалтын стандартын хэрэглээг оролцогчдод практик байдлаар биечлэн зааж сургасан. Мөн хоол зүйч өсвөр үеийнхний дархлааг дэмжих хооллолтын зөвлөгөөг хүргэж, олж авсан мэдлэгийг батжуулах "АХА" танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулан, холбогдох гарын авлага, брошюрыг нийт оролцогчдод тарааж ажиллав. Үйл ажиллагааны явцад танхимын агааржуулалт, гар ариутгал, хүн хоорондын зай барилт зэрэг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн ажилласан.

Энэхүү өдөрлөгийг зохион байгуулснаар ажилчид болон үйлчлүүлэгчдийн халдварт өвчнөөс сэргийлэх мэдлэг, хандлага дээшилж, гараа зөв угаах, амны хаалт тогтмол хэрэглэх зэрэг эрүүл ахуйн зөв дадал хэвших чухал суурь тавигдсан байна. Түүнчлэн эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлснээр эмнэлгийн дотоод орчны халдвар хамгааллын дэглэм сахилт сайжирч, халдварт өвчин дэгдэх эрсдэлийг бууруулах өндөр ач холбогдолтой үр дүнд хүрлээ.

3.8. Чанарын сургалт

Зохион байгуулагч, хамтарсан байгууллага	Сургалтын нэр	Сар өдөр	Менежер	Чанарын багийн гишүүн	Удирдах ажилтан	Эмч	Тусгай мэргэжилтэн	Бусад	Бүгд тоо
Хүний эрхийн үндэсний комисс НЭМГ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, хангамж бэлэн байдал	2026.02.12	1						1
Хүний эрхийн үндэсний комисс НЭМГ	Эрүүл сэндийн санхүүжилт, даатгалын тогтолцоо	2026.02.12			1				1

Архивын ерөнхий газар	Архивын үйл ажиллагааны нийтлэг журам, танилцуулга, хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй	2026.01.27 2026.01.30	1				2	1	4
НЭМГ	Shilen.gov.mn-ийн 2,0 хувилбар	2026.02.11					1		1
Монголын сувилагчдын нийгэмлэг болон ХБНГУ-ын эмнэлгийн эрүүл ахуйн нийгэмлэг	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үнэ цэнэ	2026.03.09				1	1		2
НЭМГ	Байгууллагын стратеги төлөвлөлт ба тэнцвэржүүлсэн үнэлгээний картыг нэвтрүүлэх нь	2026.03.27	1		1				2
Нийслэлийн архивын газар	Е-DOC системийн шинэчилсэн хувилбарын танилцуулга	2026.04.17	1	1	2	2	3	1	10
Жендерийн үндэсний хороо	Жендерийн эрх тэгш байдлыг хангах сарын аяны сургалт	2026.04.20				1			1
НЭМГ	Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журмын танилцуулга сургалт	2026.04.01	1						1

Дүгнэлт: 2026 оны хагас жилийн байдлаар чанар сайжруулах аян – 3 удаа, тэмцээн – 1 удаа, разбор хэлэлцүүлэг – 2 удаа, илтгэл судалгаа - 4 удаа, өдөрлөг – 2 удаа тус тус зохион байгуулсан ба бусад байгууллагатай хамтран ажлын байранд 3 удаагийн том хэмжээний сургалтад давхардсан тоогоор 58 орчим эмч, мэргэжилтэн, ажилтан хамрагдсан. Дотооддоо ажлын байрны тасралтгүй сургалтад эмч, мэргэжилтний мэргэжлийн ур чадавхыг дээшлүүлэх сардаа 5-6 удаа сургалтад 362 орчим мэргэжилтэн давхардсан тоогоор хамрагдсан.

Дөрөв. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангах, үнэлэлт дүгнэлт өгөх, түүний мөрөөр цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр

Чанар сайжруулах төлөвлөгөөг 7 чиглэлээр – 37 ажил төлөвлөж үүнээс хагас жилийн байдлаар 18 ажил биелэгдэж, 6 ажил хагас хэрэгжиж төлөвлөгөөний биелэлт 77.6%-тай байна.

№	ЭМТҮЧАБ-ын хурал	Хийсэн хугацаа	Хэлэлцсэн асуудлын тоо	Шийдвэрлэсэн асуудал
1.	ЭМТҮЧАБ-н багийн хурал 1	2025.01.12	2	Эмтүчаб-н баг 2026 оны төлөвлөгөө хийгдэх ажлыг тайлбарлан, танилцуулсан.
2.	ЭМТҮЧАБ-н багийн хурал 2	2025.05.18	2	Ижил мэргэжилтний, гардан үйлдлийн, цэвэрлэгээ үйлчилгээний стандартын үнэлгээний улирал тутмын үнэлгээний дүн

Орон тооны бус гишүүдийн ЭМТҮЧАБ-н багийн үйл ажиллагаанд татан оролцуулахаар тохиолдол, эрсдэлийг бүртгэн мэдээлэх талаар сургалт тогтмол орж байна.

Тав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж зааврыг мөрдүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах чиглэлээр.

ЭМТҮЧАБ-ын багийг сэргээн засах төвийн даргын 2025 оны А/37 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, багийн ажиллах журмыг хавсралтаар баталсан.

Чанарын дотоод хяналтыг 8 чиглэлээр хяналтын чек лист хяналт хийж байна. Нийтдээ 28 хяналтын хуудастай, 1 хуудас шинээр хийсэн байна.

- о Эмчилгээний тасаг шинээр эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах MNS 7014:2023 стандартын дагуу гадаад дотоод орчны үнэлгээний хуудсаар хяналт тавин ажиллаж байна.

Хийсэн хяналтын чиглэл бүрээр доорх загвар дагуу тоймлон бичих.

- 2026 оны хагас жилийн байдлаар тасаг нэгж бүр өвчний түүхэнд 2 удаагийн ижил мэргэжилтний үнэлгээ хийсэн. Өвчний түүх хөтлөлт 95.3% байна.
- Эмчилгээ оношилгооны чиглэлээр хийсэн хяналтын талаар
 - ✧ Сувилагч, нарын сувилгааны түүх, анхан шатны маягт хөтлөлтөд ижил мэргэжилтний үнэлгээг нийт 2 удаа 10 картад хийхэд хөтлөлт 93.1% байна.
 - ✧ Түгээмэл үйлдлийн стандарт мөрдөлтөд үнэлгээг нийт 2 удаа 14 сэдвээр хийсэн стандарт мөрдөлт 84.3-96.7% байна.

Хэрэгжүүлсэн ажиллагааны талаар

- Өвчний түүх хөтлөлтийг сайжруулан ажилласан.
- Сувилахуйн түүх хөтлөлт сэдвээр лекц дадлага хосолсон сургалтыг тухай бүрд зохион байгуулан үр дүнг тооцон ажиллаж байна.

Дүгнэлт: Хяналт хийснээр стандартын суурь үнэлгээг гарган ирэх жилийн үзүүлэлттэй харьцуулан ахицыг гарган ажиллахаар төлөвлөж байна.

Зургаа. Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, магадлан итгэмжлэл, мэргэжлийн хяналтын шалгалтын дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр

6.1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам батлах тухай” 43 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” А/346 дугаар тушаалын дагуу харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2025 оны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгалтаар “82,3%” үнэлэгдсэн.

6.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн баталсан 2026 оны 04 тоот удирдамжийн дагуу 2026 оны 04 сарын 21-ээс эхлэн ажлын 10 хоногийн хугацаанд төвийн 2024, 2025 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн баримтад хяналт шалгалт хийн, зөвлөмж ирүүлсэн. Цаашид зөвлөмжийн хэрэгжилтийг хангахаар дотооддоо хяналт тавин ажиллаж байна.

Долоо. Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй халдварын сэргийлэлт, хяналтын, эмчилгээний, ёс зүйн, эмийн, болон бусад хороо, зөвлөл, албадтай

хамтран ажиллан, үйл ажиллагаанд хяналт тавьж, чанар сайжруулах үйл ажиллагаанд татан оролцуулах талаар

7.1 Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйг сайжруулах чиглэлээр хийсэн ажлууд

№	Хамтран хийгдсэн үйл ажиллагааны төрөл/ аян, шалгалт, сургалт, тэмцээн, хэлэлцүүлэг	Сэдэв	Хийсэн сар өдөр	Хамрагдсан ажилтны тоо	Үр дүн
1.	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2026 оны 03 сарын 06-ны өдөр Ёс зүйн багаас нийт эмэгтэй ажилтнуудад урам зориг өгөх, талархлын үгтэй захидал өгч, баяр хүргэлээ. Энэ нь ажилчдын хоорондын хүндэтгэл, эерэг уур амьсгалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа болсон.	Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих өдөр	2025.03.06	Төвийн 33 ажилтан	Энэхүү үйл ажиллагаа нь ажилтнуудын харилцан хүндэтгэл, байгууллагын эерэг соёлыг бэхжүүлнэ.
2.	Монголын сувилагчдын нийгэмлэг болон ХБНГУ-ын эмнэлгийн эрүүл ахуйн нийгэмлэг хамтран зохион байгуулсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба үнэ цэнэ” сэдэвт сургалтаар эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, мэргэжлийн үнэт зүйл, өвчтөн төвтэй тусламж үйлчилгээ, хамт олны эерэг харилцаа зэрэг сэдвээр мэдлэг олгож, оролцогчдын ёс зүйн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн агуулгыг хүргэсэн.	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба үнэ цэнэ	2026.03.09	Төвийн 2 ажилтан	Сургалтад хамрагдсан ажилчид олж авсан мэдлэг, мэдээллээ тасгийн хамт олондоо түгээн, өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллах ач холбогдолтой болсон бөгөөд байгууллагын ёс зүй, үйлчилгээний чанарыг сайжруулахад үр нөлөөтэй
3.	Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй,	2025.05.04	Төвийн 19 ажилтан	Энэхүү үйл ажиллагаа нь ажилчдын

	мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор уг сургалтыг ажлын байран дээр зохион байгууллаа. Сургалтын хүрээнд “Урмын үгээр самбараа дүүргэе” урианы дор эерэг хандлага төлөвшүүлэх нэмэлт үйл ажиллагааг зохион байгууллаа. Ажилтнууд хоорондоо нэг нэгэндээ зориулан урмын үг, талархлын үгс бичиж, самбарт байршуулсан. Үүнд: • Хамт олныхоо хөдөлмөрийг үнэлсэн талархлын үгс • Өдөр тутмын ажлыг урамшуулсан сэтгэлийн үгс • Багийн уур амьсгалыг дэмжсэн уриалга, урам зоригийн өгүүлбэрүүд	үнэ цэнэ			хоорондын харилцааг ойртуулж, эерэг уур амьсгал бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.
--	---	----------	--	--	---

7.2 Цусны аюулгүй байдлын талаар

№	Хамтран хийгдсэн үйл ажиллагааны төрөл/ хяналт аян, шалгалт, сургалт, тэмцээн, хэлэлцүүлэг/	Сэдэв	Хийсэн сар өдөр	Хамрагдсан ажилтны тоо	Үр дүн
1.	“Авлагагүй донор” сургалт	Авлагагүй донор	2026.04.13	24	Сургалтын дараа шууд болон дараагийн аянаар цусаа өгөхөөр бүртгүүлэх ажилчдын идэвх өснө. Зөвхөн нэг удаа өгөөд зогсохгүй, жилд 1-2 удаа тогтмол цусаа бэлэглэдэг “Хүндэт донор”-ын эгнээнд шилжих ажилчдын

					суурь тавигдана.
--	--	--	--	--	------------------

7.3 Эмийн эмчилгээний хороотой хамтран хийсэн үйл ажиллагаа /эмийн хороогүй эм хариуцсан ажилтантай./

№	Хамтран хийгдсэн үйл ажиллагааны төрөл/ хяналт шалгалт, сургалт, тэмцээн, хэлэлцүүлэг	Сэдэв	Хийсэн сар өдөр	Хамрагдсан ажилтны тоо	Үр дүн
1.	Чанарын багаас хугацаат эмийн самбар, эмийн нөөцөд хяналт тавин ажилладаг.	-	Улирал тутамд	-	Эмийн нөөцийн бэлэн байдлыг хангах, эмийн хугацаанд хяналт тавин эрсдэлээс сэргийлэх

7.4 Халдварын сэргийлэлт хяналтын талаар

№	Хамтран хийгдсэн үйл ажиллагааны төрөл/ хяналт шалгалт, сургалт, тэмцээн, хэлэлцүүлэг	Сэдэв	Хийсэн сар өдөр	Хамрагдсан ажилтны тоо	Үр дүн
1.	ХСХ-ын чиглэлээр мөрдөгдөж буй тушаал шийдвэрийг Эрүүл үрс төвийн ажилчдад сургалт	ХСХ-н мөрдөгдөж буй тушаал шийдвэр	2026.03 .25	30	Сургалтын өмнөх тест дундаж хувь 85%, Сургалтын дараах тест дундаж хувь 94% болж сайжирсан үр дүнтэй ажиллалаа.
2.	Шинэ ажилтанд ХСХ-ын чиглэлээр чиг баримжаа олгох, халдварт өртөх болон өртөлтийн дараах халдвараас сэргийлэх мэдлэг олгох сургалт	Халдварт өртөх болон өртөлтийн дараах халдвараас сэргийлэх	2025.03 .25 2025.09 .16	2	Сургалтын өмнөх тест дундаж хувь 76%, сургалтын дараах тест дундаж хувь 85% болж сайжирсан үр дүнтэй ажиллалаа.
3.	ЭМС-н А/537 тоот тушаалын 1-р хавсралтын дагуу Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх талаар сургалт	“Гар угаах-халдваргүйжүүлэх	2026.02 .13 2026.05 .22	58	Сургалтын өмнөх тест дундаж хувь 82% сургалтын дараах тест дундаж хувь 89% болж сайжирсан үр дүнтэй ажиллалаа.
4.	ЭМС-н 2025 оны 05 сарын 01-ны өдрийн А/173, 2025 оны 05 сарын 09-ны өдрийн А/193 тоот тушаалын дагуу	Эмнэлгийн хог хаягдлыг ангилах, зөөвөрлөх, хадгалах	2026.02 .25 2026.05 20	61	Сургалтын өмнөх тест дундаж хувь 84% , Сургалтын дараах тест дундаж хувь 91% болж сайжирсан үр дүнтэй

	нийт ажилчдад сургалт явуулна.				ажиллалаа.
5.	ЭМС-н 2025 оны 05 сарын 01-ны өдрийн А/173, 2025 оны 05 сарын 09-ны өдрийн А/193 тоот тушаалын дагуу хог хаягдлын хяналт үнэлгээ хийнэ.	ЭМС-н 2025 оны 05 сарын 25-ны өдрийн А/173 тоот тушаалын дагуу Хог хаягдлын ялган ангилалт, менежментэд нийт 4 удаагийн хяналт үнэлгээ хийсэн.	2026.01.23 2025.04.29	6	ЭМС-н 2025 оны 05 сарын 01-ны өдрийн А/173, 2025 оны 05 сарын 09-ны өдрийн А/193 тоот тушаалын дагуу Хог хаягдлыг түр хадгалах цэгт нийт 2 удаа буюу 2026 оны 01 сарын 23, 2026 оны 04 сарын 29-ны өдрүүдэд хяналт үнэлгээ хийхэд, дундаж хувь 85%-тай үнэлэгдэж гарсан алдаа зөрчлийг тухай бүрд нь арилгуулан ажиллалаа.
6.	Эмнэлгийн эм тарианы нөөц, хугацаа, эрүүл мэндийн ажилтны хамгаалах хувцас хэрэглэл, халдваргүйжүүлэх цэвэрлэгээний бодисын нөөцөд хяналт тавьж ажиллана.	Эм эмнэлгийн хэрэгслийн нөөц ариутгал	Улирал бүр	-	Эрүүл үрс төв нь 2026 онд эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодисын нөөцийн судалгааг гаргаж 1 сарын нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.
7.	ЭМС-ийн 2019 оны 11 сарын 29-ны А/537 тоот тушаалын 9 дүгээр хавсралтын дагуу Стандарт тусгаарлах өрөө Class S хавьтал болон туслын замаар дамждаг халдварын үед ашиглах өрөөний бэлэн байдлыг хангаж ажиллана.	Тусгаарлах өрөөг тохижуулах	2026.03	-	ЭМС-ийн 2019 оны 11 сарын 29-ний А/537 тоот тушаалын 9 дүгээр хавсралтын дагуу Стандарт тусгаарлах өрөө Class S хавьтал болон туслын замаар дамждаг халдварын үед ашиглах тусгаарлах өрөөний бэлэн байдлыг тогтмол хангаж ажиллаж байна.
8.	Шинэ ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулна.	Урьдчилан сэргийлэх үзлэг	2026.03.02 2026.03.16	2	2026 оны хагас жилийн байдлаар Эрүүл үрс төвд 2 ажилтан шинээр ажилд орсон. Ажилд орсон ажилтныг ЭМС-ийн 2019 оны 11 сарын 29-ний А/537 тоот тушаалын

					гуравдугаар хавсралтын дагуу шинэ ажилтны урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан дүгнэлтийг хавсарган ажиллалаа.
--	--	--	--	--	--

Найм. Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын талаар мэргэжлийн нийгэмлэг холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт, судалгаа хийх, туршлага судлах, зөвлөх үйлчилгээг зохион байгуулах чиглэлээр

№	Хамтран ажилласан байгууллагын нэр	Хамтран хийгдсэн үйл ажиллагааны төрөл/ хяналт шалгалт, сургалт, тэмцээн, хэлэлцүүлэг	Хийсэн үйл ажиллагааны сэдэв	Хийсэн он сар өдөр	Хамрагдсан ажилтны тоо	Үр дүн
1.	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Бяцхан тэмүүлэл” төв	Кейс хэлэлцүүлэг	Сэргээн засах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн дундах кейс хэлэлцүүлэг	2026.03.25	3	Хүүхдэд үзүүлж буй тусламж үйлчилгээний талаарх мэдлэг туршлага, мэдээ мэдээллээ хуваалцах
2.	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Хан туул” төв	Туршлага солилцох	Туршлага солилцож үйл ажиллагаатай танилцах	2026.05.20	3	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Хан туул” төвийн үйл ажиллагаатай танилцаж, харилцан туршлага солилцож, ажилласан.

Ёс. Үйлчлүүлэгчидтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах, сэтгэл ханамжийн судалгаа явуулж, үр дүнг тооцох талаар

9.1 Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж.

2025 оноос эхлэн сэтгэл ханамжийн судалгааны түүврийн хэмжээг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 сарын 01-ны А/346 тоот тушаалын дагуу статистикийн үндсэн зарчим болон байгууллагын үйлчлүүлэгчдийн бодит тоон мэдээлэлд тулгуурлан тооцоолол хийн итгэлцлийн түвшинг 95%, алдааны хязгаарыг 5% байхаар төлөвлөн сард 20 үйлчлүүлэгчээс судалгаа аван ажиллаж байна.

Сэтгэл ханамж	2025 оны хагас жилийн байдлаар	2026 оны хагас жилийн байдлаар
Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн хүний тоо	1260	2010
Сэтгэл ханамжийн судалгаанд авсан үйлчлүүлэгчийн тоо	118	92
Үйлчлүүлэгчийн эерэг сэтгэл ханамжийн хувь	90%	97%

Дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан:

1. Угтах үйлчилгээ ба Хөтчийн зохион байгуулалт:

- **Хөтчийн үйлчилгээг тогтмолжуулав:** Амбулаторийн хэсэгт үйлчлүүлэгчдийг угтах, мэдээллээр хангах, шаардлагатай кабинет руу чиглүүлэх "Хөтөч ажилтан"-ыг ажиллуулж эхэлснээр иргэдийн төөрөгдөл, хүлээгдлийг бууруулсан.
- **Мэндчилэх соёл:** "Үйлчлүүлэгчийг инээмсэглэн угтах" стандартыг нийт ажилтнуудын дунд хэвшүүлж, өглөөний шуурхай зөвлөгөөнөөр харилцаа хандлагын зааварчилгааг тогтмол өгч ажиллав.

2. Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, зөвлөгөө:

- **Мэдээлэл өгөх чадамжийг сайжруулав:** Эмч нар үйлчлүүлэгчид өвчний онош, шинжилгээний хариу, эмийн гаж нөлөөг энгийн, ойлгомжтой хэллэгээр тайлбарлан өгдөг "Зөвлөх цаг"-ийг үзлэг бүрд гаргаж хэвшүүлэв.
- **Идэвхтэй сонсох ур чадвар:** Эмч, сувилагч нарт зориулсан "Үйлчлүүлэгчийг сонсох, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх" богино хэмжээний сургалтыг зохион байгуулж, үйлчилгээний чанарт ахиц гаргасан.
- Тусламж үйлчилгээний стандарт мөрдөлтийн талаар тохиолдолд суурилсан 1 удаагийн хэлэлцүүлэг хийсэн.

3. Амбулаторийн зохион байгуулалт ба Орчин:

- **Цаг авалтын оновчлол:** Амбулаторийн тусламж үйлчилгээний хүлээгдлийг бууруулах зорилгоор үзлэгийн цагийн товлолтыг нарийвчилж, дараалал зохицуулалтыг сайжрууллаа.
- **Дэд бүтцийн шинэчлэл:** Үйлчлүүлэгчдийн тав тухыг хангах үүднээс **хувцасны өлгүүрийн багтаамжийг нэмэгдүүлж**, ариун цэврийн өрөөний тохижилт, ариун цэвэрт өдөр тутмын хяналтын хуудсаар (checklist) хяналт тавьж ажиллав.

Арав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах олон улсын туршлагыг нэвтрүүлнэ.

№	Олон улсын туршлагын нэр, чиглэл	Хэрэгжүүлэх талаар хийсэн ажил	Оролцогчийн тоо
1.	Японы ажлын байрны менежментийн "5S" аргачлал	Сэргээн засах хэрэглэгдэхүүн, бөмбөг, тоглоомуудыг хүүхдэд аюулгүй, эмх цэгцтэй байлгахад тасгуудад "5S" сургалт зохион байгуулж, өрөөний зохион байгуулалтыг сайжруулав.	22 ажилтан

Арван нэг. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудлаар чанарын судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран хийнэ.

11.1 Эмнэлгийн ажилтын сэтгэл ханамж

Сэтгэл ханамж	2025 оны хагас жилийн байдлаар	2026 оны хагас жилийн байдлаар
Ажиллаж буй эмнэлгийн ажилтны тоо	30	36

Сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан тоо	28	33
Ажилчдын эерэг сэтгэл ханамжийн хувь	97%	98,6%

Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа :

- Байгууллагын удирдлагын зүгээс ажилтнуудынхаа эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хувийн хамгаалах хэрэгсэл (амны хаалт)-ийг нэгдсэн зохион байгуулалттайгаар тарааж, дэмжлэг үзүүлэн ажиллалаа.
- Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэлхийн өдөртэй холбогдуулан хорт хавдрын талаарх зөвлөмж, хавдраас урьдчилан сэргийлэх талаар сургалтыг 2026 оны 03 сарын 06 өдөр “Эрүүл үрс төв”-ийн уламжлалтын их эмч Б.Лхамдулам, Ахлах сувилагч Д.Даваадулам, сувилагч М.Нямцэрэн, туслах сувилагч Х.Мөнхшүр нар хамтран зохион байгуулан ажилласан.

Хүний нөөцийн хөгжих боломж:

- Эрүүл үрс төвийн хүүхдийн эмч А.Оюунсайхан нь ЭХЭМҮТ-д “Хүүхдийн мэдрэлийн судлал” чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдаж, 2026 оны 4-р сард амжилттай төгссөн.
- Эрүүл үрс төвийн хүүхдийн эмч Л.Эрдэнэбулаг нь ЭХЭМҮТ-д “Хүүхдийн дүрс оношилгооны судлал” чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдаж, 2026 оны 4-р сард амжилттай төгссөн.
- 2 сувилагч төрөлжсөн мэргэжлийн сургалтад суралцаж байна. Үүнд:
 - Хүүхдийн сувилагч -1
 - Сэргээн засах эмчилгээний сувилагч -1 суралцаж байна.
- Мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн, дээшлүүлэх сургалтаас гадна, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, боловсролын зэргийг ахиулах чиглэлд тодорхой ахиц гарч, 2026 онд **тус төвийн 4 эмч Анагаах ухааны магистрантурт** суралцаж байна. 1 эмч магистр зэрэгтэй болсон байна.
- Хүүхдийн сэргээн засах төвийн хэмжээнд хүний нөөцийн чадавх 2025 онтой харьцуулахад тогтмол нэмэгдэж байгаа төдийгүй 3 сувилагч **'Ач' АУИС-д Нийгмийн эрүүл мэндийн судлаачийн** мэргэжлээр суралцаж байна. Ингэснээр хүүхдийн сэргээн засах төв нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртээмжтэй хүргэн, судалгаа шинжилгээг илүү боловсронгуй зохион байгуулах боломжтой болно.

Арван хоёр. Үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн мэргэжилтний аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах орчин бүрдүүлэхэд шаардлагатай зохицуулалтын талаар санал гаргаж, шийдвэрлүүлнэ.

12.1 2026 оны хагас жилийн байдлаар 11 тохиолдол бүртгэгдсэн.

№	Чиглэл	1А	1Б	2	3	Алдаа
1	Үйлчлүүлэгчийг танин тодруулга	1				
2	Харилцааны дутагдал, доголдол					
3	Эмийн аюулгүй байдал					
4	Барилга байгууламжтай холбоотой	1				
5	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний халдвар					
6	Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унасан			1		
7	Бусад: Эмнэл зүйн удирдамж мөрдөөгүй тохиолдол		1			
8	Түгээмэл үйлдлийн стандарт мөрдөөгүй тохиолдол		2	1		
9	Эрүүл мэндийн анхан шатны бичиг	2				

	баримтжуулалтын тохиолдол					
10	Тоног төхөөрөмжийн аюулгүй заавар мөрдөөгүй			1		
11	Байгууллагын дотоод журам мөрдөөгүй	1				

Тохиолдлыг илрүүлсэн байдал:

- Иргэдээс – 0
- Эмч, ажилчдаас – 7
- Чанар, сувилахуй, халдвар хяналтаар хяналтаар -4
- Тасгийн арга зүйч – 0
- Бусад-0

№	Нөлөөлөх хүчин зүйлсийг	1А	1Б	2	3	Алдаа
1	Үйлчлүүлэгчийн хүчин зүйл	2		1		
2	Хувь хүн/ ажилтны хүчин зүйл	1	2	2		
3	Ажлын болон үйлчилгээний орчны хүчин зүйл					
4	Багийн хүчин зүйл		1			
5	Баримт бичиг/ технологийн хүчин зүйл	2				
6	Бүтэц, зохион байгуулалтын хүчин зүйл					

Гарсан үр дагавар :

- Иргэнд эдийн засгийн хохирол учирсан – 0
- Байгууллагад хохирол учирсан –0
- Эмийн зардал нэмэгдсэн- 0
- Эмч, эмнэлгийн ажилтанд эдийн засгийн хохирол учирсан – 0,
- МХГ-с торгуулсан – 0 удаагийн байна.

Тохиолдол бууруулах чиглэлээр төвийн хэмжээнд 2024 оны А/112 тоот тушаал батлагдсантай холбогдуулан төвийн даргын А/33 тоот тушаалыг шинэчлэн батлан ажилласан. Тус тушаал шинэчлэгдсэнтэй холбогдуулан төвийн хэмжээд тохиолдол хэрхэн бүртгэх мэдээлэх, тохиолдлыг яагаад бүртгэх шаардлагатай талаар сургалт зохион байгуулан ажилласан. Сургалт зохион байгуулсантай холбоотойгоор ажилчид тохиолдлыг мэдээлэх нь нэмэгдсэн байна.

12.2 Эрсдэлийн удирдлагын багийг төвийн даргын 2021 оны А/19 тоот тушаалаар орон тооны бус 5 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, эрсдэл тохиолдлыг чанарын баг хариуцан ажиллаж байна. 2026 нийт 9 чиглэл 31 ажлыг төлөвлөн ажилласан.

Тасаг, нэгжид эрсдэлийн үнэлгээ хийж, тасаг, нэгжид дотоод хяналт үнэлгээг тогтмол хийсэн.

- ✓ Эмчилгээ, оношилгоо, тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдэл
- ✓ Халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл
- ✓ Эм зүй, эм био бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдалтай холбоотой эрсдэл
- ✓ Тоног төхөөрөмж, санхүү бүртгэл, мэдээлэлтэй холбоотой эрсдэл
- ✓ Гадаад, дотоод орчинтой холбоотой эрсдэл

Нийт 31 эрсдэлийг тодорхойлж бууруулах ажил зохион байгуулж ажилласан.

Эрсдэлийн үнэлгээний дагуу хэрэгжүүлсэн ажил:

- Яаралтай тусламжийн шүүгээний бэлэн байдлыг ханган, өндөр эрсдэлт эмийн тушаалыг батлуулах, эмийн нөөцийг бүрдүүлэн ажилласан.
- Гар угаах халдваргүйжүүлэх гардан үйлдлийн хяналтыг тушаалаар 2 удаа авагдах байсныг төвийн онцлогт тохируулан улирал тутамд үнэлэн ажиллаж гар угаах халдваргүйжүүлэх чадвар нэмэгдсэн.
- Хоолны хордлого үүсэхээс сэргийлэн хоол үйлдвэрлэлийн явцад хяналт тавин, дээж авалт, халдварыг сэргийлэлт хяналтын журмыг баримтлан ажиллаж байна.

- Үйлчлүүлэгчийг халуун хоол цайнд түлэгдэхээс сэргийлж халуун болон идэхэд тохиромжтой хоолны тэмдэг тэмдэглэгээг тасаг нэгжид байршуулан ажиллаж байна.
- Эмч эмнэлгийн ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдүүлэн ажиллах сургалтыг 1 удаа орсон байна.
- Төвийн хүрээнд мөрдөгдөж буй тушаал, журам, заавар болон шийдвэрийг танилцуулж төвийн нийт ажилчдад сургалт зохион байгуулсан.
- Эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчийн хувийн болон эрүүл мэндийн мэдээллийн нууцыг хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох хууль, дүрмийн хүрээнд эмнэлгийн бүх компьютерыг бүрэн коджуулан ажиллаж байна.

Дүгнэлт.

2026 оны эхний үнэлгээнд:

- Ноцтой эрсдэл 6 буюу 19.3%
- Өндөр эрсдэл 21 буюу 67.7%
- Дунд эрсдэл 2 буюу 6.5%
- Бага эрсдэл 2 буюу 6.5% тус тус эзэлж байсан.

2026 оны хагас жилийн үнэлгээнд:

- Ноцтой эрсдэл 4 буюу 12.9%
- Өндөр эрсдэл 17 буюу 54.8%
- Дунд эрсдэл 7 буюу 22.6%
- Бага эрсдэл 3 буюу 9.7% тус тус эзэлж байна

Ноцтой, өндөр эрсдэлийг 6.4-12.9%-аар бууруулан ажилласан байна.

Арван гурав. Байгууллагын хэмжээнд чанар сайжруулах талаар хэрэгжүүлж буй бүх арга хэмжээг бүртгэн, мэдээллийн сан байгуулж олсон ололт амжилтыг байгууллагынхаа бүх тасаг/нэгжүүдэд дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж урамшуулан ажиллана.

III дугаар улиралд чанар сайжруулах арга хэмжээнүүдийн нэгдсэн цахим санг бүрдүүлж, мэдээллийг системтэйгээр бүртгэж эхлэхээр бэлтгэн ажиллаж байна. Улмаар IV дүгээр улиралд шалгарсан шилдэг туршлагаудыг нийт тасаг, нэгжүүдэд дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, идэвх санаачилгатай ажилласан баг хамт олныг албан ёсоор үнэлж урамшуулахаар төлөвлөж байна. Энэхүү хугацаанд алдаа, оноог хамтдаа хэлэлцсэнээр байгууллагын хэмжээнд тасралтгүй сайжруулалтын соёлыг бүрэн нутагшуулах юм.

Арван дөрөв. Байгууллагын цахим хуудсанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл тавих, хамтын мэдээлэл солилцох, суралцах, эргэх холбооны хэрэгсэл болгох зорилго бүхий чанар, аюулгүй байдлын буланг тогтмол ажиллуулах талаар

№	Тухайн жил байгууллагын цахим хуудсанд тавьсан мэдээллийн тоо	2026 оны хагас жилийн байдлаар
1.	Цахим хуудсанд хандсан хүний тоо	11000 дагагчтай болсон байна.
2.	Чанарын буланд тухайн жилд шинэчилж тавьсан мэдээллийн тоо	3

Арван тав. Байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлүүлэх ажлыг хамтран ажиллах, тэдний хүсэлтийг шийдвэр гаргалтад тусгасан талаар эргэн мэдээлэх талаар

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв нь өргөдөл, гомдол, зөрчлийг QR кодоор авч ажиллаж байна. Одоогоор манай төвд өргөдөл, гомдол ирээгүй бөгөөд талархал 11-11 төвөөс 1, цахим хуудсаар 3, талархлын дэвтэрт 45 ирсэн байна.

Арван зургаа. Шинэ ажилтныг чиглүүлэх сургалтын хөтөлбөрт чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар тусгах, эмч, эмнэлгийн ажилтнуудад чанар, аюулгүй байдлын сургалтыг тогтмол зохион байгуулна.

Сэргээн засах Эрүүл үрс төвд 2026 оны хагас жилийн байдлаар 2 туслах сувилагч шинээр ажилд орж, шинэ ажилчдадаа ажлын байр, хийж гүйцэтгэдэг ажлуудыг танилцуулан төвийн хүрээнд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам болон хийгдэж буй эмнэлгийн тусламж үйлчилгээг зааж сурган ажиллуулж байна.

Арван долоо. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, өөрийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын үйл ажиллагааг үнэлнэ.

№	Чанарын үзүүлэлт	2025 оны хагас жилийн байдлаар	2026 оны хагас жилийн байдлаар
1.	Үндсэн үзүүлэлт	50%	52.3%
2.	Хүүхдийн суурь өвчлөл илрүүлэлт, түүний үр дүн	49.3%	61.1%
3.	Сэргээн засах, уламжлалт эмчилгээ, сувилгааны стандарт, эмнэлзүйн удирдамж зааврыг мөрдүүлэн хэрэгжилтийн мөрдөлт	50%	59.9%
4.	Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдалд хяналт, шалгалт, үнэлгээ, тохиолдол эрсдэлийн үр дүн	50%	67.6%
5.	Эрүүл ахуй, халдварын сэргийлэлтийн үйл ажиллагаа	50%	63.3%
6.	Байгууллагын соёл, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, аюулгүй байдал	96%	97%

Арван найм. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр тухайн байгууллагад мөрдөх дүрэм, журам заавар, хяналтын хуудсыг хуульд нийцүүлэн боловсруулан, мөрдүүлж, хэрэгжилтийг ханган ажиллана.

№	Шинээр боловсруулсан удирдамж зааврын нэр	Ажилчдад танилцуулах талаар хийсэн үйл ажиллагаа хамрагдсан хүний тоо
1.	Хөдөлгөөн засал эмчилгээний удирдамж	Удирдамжийг танилцуулж, сургалт зохион байгуулсан- 21
2.	Хавтгай тавхай илрүүлэг, оношилгооны удирдамж	Удирдамжийг танилцуулж, сургалт зохион байгуулсан- 21

Арван ёс. Эрүүл мэндийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд чанар аюулгүй байдлын ажлыг нэг шалгуур болгон оруулж дүгнэнэ.

III дугаар улиралд нийт тасаг, нэгжүүдэд чанар сайжруулах арга хэмжээнүүдийг дэлгэрүүлэх "Чанарын өдөрлөг"-ийг зохион байгуулж, идэвх санаачилгатай ажилласан баг хамт олныг албан ёсоор үнэлж урамшуулахаар төлөвлөж байна.

Хорь. ЭМТҮЧАБ-ын алба нь тасаг/нэгжүүдэд чанар, аюулгүй байдлын баг байгуулж ажиллах талаар

Тасгийн багийн гишүүд долоо хоногт 1 удаа, ердөө 5-10 минут цуглаж, "Өнгөрсөн долоо хоногт аюулгүй байдлын ямар эрсдэл гарсан бэ? Энэ долоо хоногт юун дээр анхаарах вэ?" гэдгийг ярилцдаг хэвшил тогтоохоор бэлтгэн ажиллаж байна.

Чанар сайжруулах үйл ажиллагааг явуулахад гарсан бэрхшээл хүндрэлтэй асуудлыг бичнэ үү.

Төсөв хөрөнгө, зориулалтын байр, тогтолцоотой холбоотой хүндрэл их байдаг. Чанарын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон ажилчдад олгох урамшуулал болон бусад арга хэмжээ зохион байгуулах, материал хэвлүүлэх зэрэгт огт төсөв байдаггүй нь үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байна.

Хүний нөөцийн хүчин зүйлтэй холбоотой ажилчдын идэвхи санаачилга муу, ажилд татан оролцуулахад болон хяналт хийхэд маш их дургүйцлээ илэрхийлдэг.

Чанарыг сайжруулах чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажлын санал, хүсэлт:

- Чанарын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон ажилчдад урамшуулал олгох болон бусад арга хэмжээ зохион байгуулах, материал хэвлүүлэх зэрэгт огт төсөв байдаггүй нь үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг.
- Эмч, сувилагч нарын мэдлэг, хандлагыг дээшлүүлэх зорилгоор тасралтгүй сэргээн засах эмнэлгүүдэд туршлага судлуулах
- Стандарт хэрэгжилтийг хянах тогтолцоог төгөлдөржүүлэх, шинэчлэх
- Мэдээ баримтыг зөв гаргуулах, баталгаажуулах ажлыг сайжруулах

Нийт ажилчдын тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах ажилд оролцох хандлагыг өөрчлөн сайжруулах, багаар ажиллах чадвар суулгах зэрэг зорилтуудыг дэвшүүлэн тавьсан.

ХЯНАСАН:

ЭМТҮЧАБ-н ДАРГА

ТАЙЛАН БИЧСЭН:

ЭМТҮЧАБ-н МЕНЕЖЕР

Л.Эрдэнэбулаг

Л.ЭРДЭНЭБУЛАГ

Б.Чирмийн

Б.ҮҮРИЙНЦОЛМОН